




НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ I АНГИ

СЭДЭВ: ЭРЧИМ ХҮЧ ҮҮССЭН ТҮҮХ






СУДЛАХ ЦАГ: 2

ЗОРИЛГО: Дулааны эх үүсвэр болох гал, модны тухай ойлголт өгнө.

ЗОРИЛТ:

-  Гал, мод дулаан ялгаруулдаг болохыг мэдэх
-  Гал, модыг ахуйн хэрэглээндээ хэрхэн хэрэглэдгийг мэдэх
-  Аюулгүй ажиллагааны дэгийг хэвшил болгох

АГУУЛГА:
















МЭДЛЭГ	ЧАДВАР
<ul style="list-style-type: none">  Гал  Мод 	<ul style="list-style-type: none">  Гал, мод дулаан ялгаруулдаг болохыг мэдэх  Гал, модыг ахуйн хэрэглээндээ хэрхэн хэрэглэдгийг мэдэх  Аюулгүй ажиллагааны дэгийг хэвшил болгох



ХАМРАХ ХҮРЭЭ: 1-Р АНГИ

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: Цуврал зураг, бичлэг, аюулгүй ажиллагааны зурагт хуудас

АРГА ЗҮЙ:

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл	Хугацаа
сэдэлжүүлэлт	<p>ҮА:1 Цуврал зураг ашиглан асуултын дагуу ярилцах</p> <ul style="list-style-type: none"> ○ Ах дүү 2 дулаацахын тулд яах вэ? ○ Галаа яаж асаах вэ? тусалцгаая  	<p>ҮА:1 Цуврал зургийг ажиглана.</p> <p style="color: green;">Ах дүү 2 дулаацахын тулд яах вэ?</p> <ul style="list-style-type: none"> ○ Хэн нэгнээс тусалцаа хүснэ ○ Гүйнэ ○ Дулаан хувцас өмсөнө ○ Гал түлнэ <p style="color: green;">Галаа яаж асаах вэ? Тусалцгаая</p> <ul style="list-style-type: none"> ✓ Чүдэнз зурна ✓ Цаас шатаана ✓ Мод шатаана 	Сурагчдын санаа бодлыг чөлөөтэй сонсох	8 минут

<p style="text-align: center;">Шинэ мэдлэг</p>	<p>YA:2 Эрт үед хүмүүс хэрхэн яаж гал гаргадаг байсан бол? Хүмүүс яагаад гал ашигладаг болсон бэ? Төсөөлөн бодоорой.</p>   <p>YA:3 Мэдээлэл өгнө. Хүй нэгдлийн үед хоёр модыг хооронд нь үрэхэд үүссэн дулаанаар гал гаргаж болдгийг нээсэн. Бичлэг үзүүлэх</p> <p>YA:4 Алжаал тайлах дасгал хийх</p> <p>YA:5 Хүмүүс галыг амьдрал ахуйдаа хэрэглэснээр ямар ач тустай вэ? Зургийг тарааж өгөөд сурагчдын саналыг сонсоно.</p>  	<p>Сурагчдын бодол</p> <ul style="list-style-type: none"> ○ Ил гал түлдэг ○ Чүдэнз асаадаг гэх мэт ○ Дулаацах гэж ○ Хоол цайгаа болгож идэхийн тулд ○ Гэрэл гаргахын тулд ○ Бие биедээ дохио өгөхийн тулд <p>YA:3 Мэдээллийг анхааралтай сонсоно. Бичлэг үзнэ Яагаад модоор үрж гал асаадаг байсан бэ? Чүдэнз болон гал гаргах тусгай хэрэгсэл байсан болов уу?</p> <p>YA:4 Алжаал тайлах дасгалын хөдөлгөөнийг зааврын дагуу хийх</p> <ol style="list-style-type: none"> 1. гар үрэх хөдөлгөөн хийнэ. 2. чүдэнз зурж буй байдал үзүүлнэ. 3. 2 гарын эрхий хуруугаар асаагуур асааж байгаа мэт хөдөлгөөн хийнэ. 4. Гал аслаа, гал аслаа     		<p style="text-align: center;">15 минут</p>
<p style="text-align: center;">Бататгал</p>	<p>YA 5 Тусгайлан бэлтгэсэн модыг ашиглан дулаан үүсгэнэ. Аюулгүй ажиллагааг хэлж өгнө./Бичлэг үзүүлнэ./</p>  <p>08 Гал түймэр.mp4</p> <ul style="list-style-type: none"> ✓Ил задгай гал түлж болохгүй ✓Шатах материалын хажууд гал гаргаж болохгүй ✓Чүдэнзээр тоглож болохгүй ✓Нойтон гараар цахилгаан хэрэгсэлд хүрч болохгүй 	<p>YA 5 Тусгайлан бэлтгэсэн модыг ашиглан дулаан үүсгэнэ Аюулгүй ажиллагааны дэгийг мөрдөнө.</p>    	<p>Аюулгүй ажиллагааны дэгийг мөрдөж хэвшил болгоход анхаарах</p>	<p style="text-align: center;">6 минут</p>

<p style="text-align: center;">Дүгнэлт</p>	<p>Ажлын хуудас №1-2-ыг ажиллуулж хичээлээ болон сурагчдын чадварыг дүгнэнэ. Ажлын хуудас №1 Галын үүсэл хөгжлийн үе шатыг дугаарлаарай.</p>  <p>Ажлын хуудас №2 Галын ач холбогдлыг нөхөж бичээрэй.</p> <div style="display: flex; align-items: center; justify-content: center;"> <div style="border: 1px solid black; width: 40px; height: 20px; margin-right: 10px;">.....</div>  <div style="border: 1px solid black; width: 40px; height: 20px; margin-left: 10px;">.....</div> </div>	<p>Ажлын хуудсыг зааврын дагуу хийж буйд хяналт тавих</p>	<p style="text-align: center;">5 минут</p>
<p style="text-align: center;">Гэрийн даалгавар</p>	<p>Галын аюулгүй байдлын талаас санамж бичиж ирээрэй.</p>		<p style="text-align: center;">1 минут</p>

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл
<p style="text-align: center;">Сэдэлжүүлэх үе</p>	<p>3x3 хүснэгтэнд модны зураг эвлүүлэх дасгал ажил хийнэ. Модны олон төрлийг хамруулсан байна. Үүнд: хус, хуш, гацуур, нарс, улиас Модны нэрийг зөв бичсэн эсэхээ слайдаас харж өөрийгөө үнэлэх</p>		
<p style="text-align: center;">Шинэ мэдлэг олгох үе</p>	<p>Модыг хүмүүс ямар зориулалтаар ашигладаг вэ? Ямар модыг ихэвчлэн түлшинд хэрэглэдэг юм бол? Яагаад? Модыг хүмүүс яах гэж түлш болгон хэрэглэдэг вэ?</p>	<p>Тавилга хийх, түлшинд хэрэглэнэ, цаас хийх Хар мод Ойд хэрэггүй болсон үхэжсэн, хортон шавжид идэгдсэн мод Хоол хийх, дулаацах, гэрэлтүүлэх</p>	

Багатган дүгнэх үе шат	<ul style="list-style-type: none"> ➢ Үзсэн хичээлийн агуулгын дагуу алжаал тайлах дасгал хийх Мод мод найгаарай Монос мод цэцэглээрэй Хар мод ургаарай Халуун дулааныг бэлэглээрэй Ногоон ойгоо цэвэрлэн Найрсаг багачуудаа дулаацуулъя ➢ Дулаан мод сэдэвтэй шүлэг дуурайн зохиох <li style="padding-left: 40px;">Дулаан мод Амттай хоолыг болгож Ам бүлийг минь дулаацуулж Харанхуй замыг гэрэлтүүлж Хэрэг болдог дулаан мод 	<ul style="list-style-type: none"> ➢ Багшийн хийсэн хөдөлгөөнийг даган хийнэ. Алгаа хавсран толгой дээрээ барин найгах Хоёр гарын хурууг салган доороос дээш чиглэлтэй сэгсрэх Суугаа байдлаас гараа өргөн дээш босох Найзынхаа хацрыг илэх Доороо нэг удаа эргэх Найз руугаа инээмсэглэн тэврэх ➢ Бэлдсэн дулаан мод сэдэвтэй шүлгийг сонсон дуурайлган шүлэг бичих
------------------------	---	--

“Эрчим хүчний зохистой хэрэглээ”

1.Сэдэв: **Үйлдвэрлэл**

2.Хамрах хүрээ: **1- р анги**

3.Зорилго: **Зуух болон нүүрсний хэрэглээний ач холбогдлыг ойлгуулах**

4.Зорилт:

- Зуух гэж юу вэ?
- Зуухны тухай мэдлэгтэй болгох
- Зуухны хэрэглээний ач холбогдлыг таниулах
- Нүүрсний тухай ойлголт өгөх
- Нүүрсний хэрэглээний тухай мэдлэгтэй болгох


5.Агуулга:

Судлагдахуун	Ур ухаан
Зуух	Зуухны тухай мэдлэгийг олгож ач холбогдлыг таниулан аюулгүй ажиллагааг мөрдөж чаддаг болгох
Нүүрс	Нүүрсний үүрэг түүний хэрэглээ ач холбогдлыг таниулах








6. Арга зүй цагийн төлөвлөлт:

1-р хичээл

Ээлжит хичээл	Үе шат	Цаг	Үйл ажиллагаа
Зуух	Сэдэлжүүлэлт	5 мин	<div style="display: flex; align-items: center;">   </div> <ul style="list-style-type: none"> -Зургийг ажиглуулах -Зургийн үйл явдлыг яриулах -Аргалыг юунд хэрэглэдэг болохыг ярилцах /гал түлэх/ -Хаана ашигладаг вэ? /тулга, зуух, пийшин г.м/ -Зуух гэдэг үгийг гаргуулах

	Шинэ мэдлэг бүтээх	15 мин	 <p>- Зуухны зураг үзүүлж түүний хэрэглээ, ач холбогдлыг ярилцах - Аюулгүй ажиллагааны дүрмийг танилцуулах - Пийшин зуух хоёрын ялгааг таниулах - Сурагчдаар ангийн паар бариулж яагаад халуун байгаа болохыг ярилцан уурын зуухны тухай мэдлэг өгөх - Хаанаас дулаан ирж байгааг ярилцах - Гэрийн зуухнаас гадна уурын зуух гэж байдаг гээд түүний хэрэглээний талаар таниулна.</p> 
			<ul style="list-style-type: none"> - Сурагчдад зуухны зураг өгч будуулах - Сурагчдын бүтээлийг самбарт өлгөн зуухны өнгөний тухай хэлэлцэн юугаар хийдэг болохыг таниулах
	Бататгал	10мин	<ul style="list-style-type: none"> - Зургийг холбоорой.  <p>Холбосон зургийг сурагчдаар тайлбарлуулах</p>
	Дүгнэлт	3мин	<ul style="list-style-type: none"> - Хэрвээ гэрт хүйтэн байвал яах вэ? - Зуухыг яах гэж хэрэглэдэг вэ? - Зуухны ач холбогдол юу вэ? - Зууханд юу түлдэг вэ? г.м баг бүрт асуулт өгөн тайлбарлуулах
	Гэрийн даалгавар	2мин	<ul style="list-style-type: none"> - Нүүрсний тухай мэдэж ирэх

2-р хичээл

Ээлжит хичээл	Үе шат	Цаг	Үйл ажиллагаа																									
Нүүрс	Сэдэлжүүлэлт	5мин	<ul style="list-style-type: none">-Багуудад хэрчмэл үсэг тараан өгч нүүрс гэсэн үг бүтээлгэнэ-Нүүрс гэсэн үгийн утгыг ярилцах-Нүүрс болон чулууг жижиг уутанд хийн бариулж ялгааг олуулах-Нүүрс чулуу 2 гаднах төрхөөрөө ямар ялгаатай байна вэ?-Нүүрс бутрамтгай, чулуу бутардаггүй болохыг хэлүүлэх-Нүүрсийг түлдэг чулууг түлдэггүй гэдгийг ойлгуулна-Эйлер Веннийн диаграмм ашиглах																									
	Шинэ мэдлэг бүтээх	15мин	<ul style="list-style-type: none">-Нүүрсний уурхайн зургийг ажиглуулан ярилцах  <ul style="list-style-type: none">-Нүүрсийг хаанаас гаргаж авдаг вэ?-Нүүрсийг хаашаа зөөвөрлөдөг вэ?-Нүүрсийг ямар улиралд их хэрэглэдэг вэ? Яагаад?-Нүүрсний ач тусыг яриулах.																									
Нүүрсний уурхай - цахилгаан станц -дамжуулах сүлжээ –түгээх сүлжээ- айл өрх																												
																												
	Бататгал	10мин	<ul style="list-style-type: none">-Нүүрсний уурхайн орд газруудтай танилцуулах-Багануур, Налайх, Оюутолгой, Шивээ – Овоо, Алагтолгой-Зургийг ажиглан нэрсийг бичүүлэх-Аль нь түлшинд хэрэглэдэггүй вэ?  <p>..... </p>																									
	Дүгнэлт	3мин	<ul style="list-style-type: none">- Нүүрс, аргал, мод гурвын ялгаа нь юу вэ? тайлбарлуулах-Өвөл яагаад илүү нүүрс хэрэглэдэг вэ? Яагаад?																									
	Гэрийн даалгавар	2мин	<ul style="list-style-type: none">-Үг бүтээж унш <table border="1"><tbody><tr><td>н</td><td>т</td><td>о</td><td>а</td><td>у</td></tr><tr><td>н</td><td>ү</td><td>ү</td><td>р</td><td>с</td></tr><tr><td>м</td><td>л</td><td>б</td><td>г</td><td>т</td></tr><tr><td>о</td><td>э</td><td>л</td><td>а</td><td>а</td></tr><tr><td>д</td><td>э</td><td>н</td><td>л</td><td>к</td></tr></tbody></table>	н	т	о	а	у	н	ү	ү	р	с	м	л	б	г	т	о	э	л	а	а	д	э	н	л	к
н	т	о	а	у																								
н	ү	ү	р	с																								
м	л	б	г	т																								
о	э	л	а	а																								
д	э	н	л	к																								



НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ I АНГИ

СЭДЭВ: ЦАХИЛГААНЫ ХЭРЭГЛЭЭ БА ХЭМНЭЛТ







СУДЛАХ ЦАГ: 5 цаг

ЗОРИЛГО: Эрчим хүчний хэрэглээг ойлгох, хэмнэх аргаас суралцана.

ЗОРИЛТ:

-  Цахилгааныг хэмнэх, зөв хэрэглэх аргыг хэвшил болгох
-  Аюулгүй ажиллагааны дэгийг хэвшил болгох

АГУУЛГА:

МЭДЛЭГ	ЧАДВАР
<ul style="list-style-type: none">  Гэрэл  Телевизор  Хөргөгч  Ус буцалгагч 	<ul style="list-style-type: none">  Аюулгүй ажиллагааны дэгийг хэвшил болгох  Цахилгааныг хэмнэх, зөв хэрэглэх аргыг хэвшил болгох

ХАМРАХ ХҮРЭЭ: 1-Р АНГИ

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН: Цуврал зураг, бичлэг, аюулгүй ажиллагааны зурагт хуудас

АРГА ЗҮЙ: Гэрлээ хэрхэн хэмнэх вэ?

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Анхаарах зүйл	Хугацаа
Сэдэлжүүлэх	Сурагчдын нүдийг боож юу болохыг тэмтэрч мэдрүүлэх -Харанхуй үед ямар бэрхшээл тулгарч буй тухай ярилцана.	Сурагчдын нүдийг боож юу болохыг тэмтэрч мэдрэх -Юу байгааг нэрлэх -Харанхуй үед ямар бэрхшээл тулгарч буй тухай ярилцана. -Юм тод харагдахгүй -унах бэртэх аюултай ...	Бие биедээ саад болохгүй байх	5 мин
Шинэ мэдлэг	Сурагчдаар ангид буй цахилгаан дулааны хэрэгслүүдийг нэрлүүлэх -Эдгээр нь бидний амьдралд зайлшгүй хэрэгцээ юм. Эрчим хүч нь гал, мод, нүүрснээс үүдэлтэй бөгөөд гэрэл нь хөгжлийн явцад бий болсон тухай тайлбарлах Гэрлийг амьдрал ахуйд үр ашигтай хэрэглэж хэмнэхийн тулд бид юу хийх ёстой вэ? \улайсдаг гэрэл, ширээний гэрэл, LED гэрэл \-ийн тухай юу мэддэгийг нь асуулт дэвшүүлэн ярилцана -Ширээний гэрлийг хэрэглэх талаар зөвлөгөө өгөх	-гэрэл -ус буцалгагч -ТВ, видео Тайлбарыг сонсох -Ашиглаагүй гэрлээ байнга унтраах -Ашигтай талбайд гэрэл асаах - Ширээний гэрлийг хэрэглэх талаар мэдэх	Өөрийн санал бодлоо чөлөөтэй илэрхийлж буйд анхаарах	

Бататгал	-Танайх болон манай анги ямар гэрэл ашиглаж буйг ажиглуулж ярилцах -Ямар гэрэл ашиглах нь хэмнэлттэй болохыг асууж бататгана.	Танайх болон манай анги ямар гэрэл ашиглаж буйг ажиглаж ярина.\LED гэрэл\ -Ямар гэрэл ашиглах нь хэмнэлттэй болохыг асууж бататгана.	Зургийг зөв зурах	
Дүгнэлт	Үгийн сүлжээ нөхөх даалгавар өгч хичээлийг дүгнэнэ.	Үгийн сүлжээ нөхөх	Үгийг зөв сонгох	
Гэрийн даалгавар	Гэрийнхэндээ тайлбарлах Гэрлээ хэмнэх, зөв ашиглах хэрэглээ болгох			

1.Сэдэв: Хөргөгч



2.Хамрах хүрээ: 1- р анги

3.Зорилго: Хөргөгчийг олон дахин онгойлгосноор цахилгаан эрчим хүч алдагдаж байдгийг мэдүүлэх

4.Зорилт:












- Хөргөгч гэж юу вэ?
- Хөргөгчийг яагаад ашигладаг вэ?
- Хөргөгчийг ямар үед онгойлгох хэрэгтэй вэ?
- Хөргөгчийг зорилгогүй олон дахин онгойлгосны уршиг

5. Арга зүй цагийн төлөвлөлт:

Үе шат	цаг	Үйл ажиллагаа
Сэдэлжүүлэлт	5мин	<p>-Сурагчдад онгойлттой байгаа хөргөгчний зургийг үзүүлж юунд дуртайг нь асуух</p>  <p>-Маша охин хөргөгчнөөс юу авахаа мэдэхгүй маш удаан онгойлгов. Гэнэт баавгай орж ирээд яагаад чи хөргөгч ийм удаан онгойлгоод байгаа юм бэ? гэж хэлээд Машад зөвлөгөө өгчээ. -Ямар зөвлөгөө өгсөн бол таамаглал дэвшүүлье гэнэ</p>
Шинэ мэдлэг бүтээх	15мин	<p>-Хүүхдүүдийн дэвшүүлсэн таамаглал дээр ярилцан зөв таамаглалыг нь сонгон авч хөргөгч удаан онгойлгосны хор уршгийн талаар ойлгуулна. -Ээж аавын цалин юу юунд зарцуулагддаг вэ? гэж асуун цахилгааны мөнгө гэсэн ойлголт дээр асуудал дэвшүүлэн ярилцана. -Цахилгааны мөнгө яагаад их гардаг болохыг ярилцах. -Хөргөгчний хаалга удаан онгойлгоход цахилгаан гүйдэг болов уу? -Хөргөгчийг гэрт хаана байрлуулж тавих нь зохистой гэж бодож байна. \ ярилцах \</p> <p>-Сурагчдад хөргөгчийг паарны дэргэд байрлуулж болохгүй хөлдөөх чадвар нь мууддаг ба цахилгаан их гүйдэг болохыг ойлгуулах. -Цахилгаанаа хэмнэхийн тулд хоосон хөргөгчийг түр таслан амрааж байх нь зөв гэдгийг хэлж өгөх. -Баавгай яагаад уурлах болсон учрыг олуулах.</p>
бататгал	10мин	 <ul style="list-style-type: none"> - Зургийг ажиглуулан ярилцах - Аль зураг нь зөв хэрэглээ болохыг ялгуулах - Цахилгаанаа хэмнэхийн тулд хөргөгчтэй яаж харьцахыг хэлүүлэх
Дүгнэлт	3мин	<p>-Сурагчдын дунд асуулт тавьж хариултыг дохиогоор авна. -Хөргөгчнөөс ямар нэгэн зүйл авахдаа эхлээд бодож байж онгойлгох хэрэгтэй \тийм, үгүй\ -Ямар нэгэн зорилгогүй хөргөгчний хаалгыг онгойлгон удаан зогсох нь буруу \тийм, үгүй\ -Хөргөгчний хаалгыг удаан онгойлоход цахилгаан гүйдэггүй /тийм, үгүй/ -Цахилгаанаа хэмнэхийн тулд авах зүйлээ бодож байж онгойлгоно.</p>
Гэрийн даалгавар	2мин	<p>-Хөргөгчид юу юу хадгалж болохыг мэдэж ирэх</p>

Хичээл №:4

<p>Сэдэлжүүлэх үе</p>	<p>ТӨМ №1 Дэс дараалуулсан тоог холбон дүрс үүсгэх зураг өгнө. Зургийг холбосноор ус буцалгагчны дүрс үүснэ. Ус буцалгагчны бичлэг үзүүлэн асуулт асууна. - Хүмүүст ус буцалгагч ямар хэрэгтэй юм бол? - Ямар ямар төрлийн ус буцалгагч байдаг вэ? - Яаж ажилладаг юм бол?</p>	<p>Ус буцалгах, ус халаах, кофе уух, юм угаах гэх мэт. Хуванцар, төмөр, шилэн, том, жижиг, ус шүүгчтэй, зөөврийн, суурин, халуунаа барьдаг, машины ус буцалгагч гэх мэт.</p>	
<p>Шинэ мэдлэг олгох үе</p>	<p>Бодит ус буцалгагч авчран ус буцалгах туршилт хийнэ. - Нэг аяга ус буцалгахад хэр их хугацаа зарцуулж байна вэ? - Нэг литр ус буцалгахад хэр их хугацаа зарцуулж байна вэ? - Танайх ус буцалгахдаа ямар зориулалтаар буцалгадаг вэ? - Ус үлддэг үү? - Ус буцалгахдаа хэрэглэх хэмжээгээрээ буцалгадаг уу? - Ус буцалгагчаар тог хэмнэх ямар арга байна вэ? Цахилгаан данх болон ус буцалгагчиндаа зөвхөн хэрэгтэй хэмжээгээр усаа тааруулж буцалгаарай. Усны чанараас хамаарч цахилгаан данх болон ус буцалгагчны дотор үүсдэг чулуужсан хэсгийг сайн цэвэрлэж байгаарай. Цэвэрхэн дотортой буцалгагч цахилгаан зарцуулалтыг 20 хувиар хэмнэнэ.</p>	<p>Нэг аяга ус буцалгахад ойролцоогоор- 1.5 минут Нэг литр ус буцалгахад ойролцоогоор- 6 минут Цай, кофе уух, ус цэвэршүүлэн уух, ямар нэгэн зүйлийг хандлах, аяга таваг угаах, гараа угаах гэх мэт. Үлддэг. Хэрэглэх хэмжээгээр буцалгадаг. Үгүй. Ойр ойрхон ус буцалгахгүй байх. Үр ашиггүй ус буцалгахгүй байх. Хэрэгтэй үедээ л ус буцалгах. Гал түлсэн үедээ гал дээр ус буцалгах.</p>	<p>Сурагчдын хариултыг гүйцэт сонсох. Асуултад хариулж чадахгүй бол дөхүүлэх асуулт асуух</p>
<p>Бататган дүгнэх үе шат</p>	<p>Айл гэр болж тоглоё. Тоглохдоо тог хэмнэх аргуудаас хэлж өгнө. Аав, ээж, хүү, охин гэсэн дүрүүд байна. Хүү охин ээж, ааваасаа асууна.жишээ нь: Охин зурагтаа үзэж дуусчихаад унтраасангүй. Миний охин зурагтаа унтраагаарай. Ээжээ яагаад? Үр ашиггүй зурагт асаалттай байх нь эрчим хүчний төлбөр их гарна гэсэн үг шүү дээ! 4 хүүхдээс бүрдсэн баг болгон тоглуулна.</p>	<div data-bbox="821 1377 1276 1713" data-label="Image"> </div> <p>Дүрээ хуваарилж аван багаараа ярилцан ямар зүйлийг ярилцахаа тохирно.</p>	<p>Багш өнөөдрийн хичээлийг дүгнэн ярилцана.</p>

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
Сэдэлжүүлэх үе 3 МИН	<p>Хүүхэлдэйн киноны зургийг харуулж ярилцах Энэ ямар нэртэй хүүхэлдэй вэ? Хүүхэлдэйн киног юугаар үздэг вэ? Та нар өдөрт хэдэн цаг зурагт үздэг вэ?</p>	<p>Хүүхэлдэйн киноны зургийг нэрлэж ярилцана. Зураг 1 -Pororo, Зураг 2- үнсгэлжин зураг 3 - Болдоггүй бор өвгөн Зурагт Хүүхэд бүрийн хариулт өөр байна. 2 цаг, 3 цаг гэх мэт</p>	
Шинэ мэдлэг олгох үе шат 15 МИН	<p>Зурагтаа үзэж дуусаад яаж унтраадаг вэ?</p>  <p>  Энэ тэмдэг юуг илэрхийлж байгаа вэ?</p> <p>Дараах зургийг ажиглаад , ярилцаарай.</p>  <p>1. 2.</p>  <p>Сурагчид зурагт унтраах, цахилгаан хэмнэх тухай бичлэг үзэж, ярилцах</p>	<p>Зурагтны залгуурыг шууд салгадаг. Огт унтраадаггүй. Орой хүртэл асаалттай байдаг.</p> <p>Зурагтыг удирдлагаар унтраасны дараа разетикийг заавал салгах ёстой.</p>  <p>Ногоон гэрэл нь зурагт асаалттай байгааг, улаан гэрэл нь унтарсан байгааг харуулна. Гэр бүлийн гишүүд өөр өөр зүйл хийж байна. Харин зурагт асаалттай байна. Энэ нь цахилгаан дэмий зарцуулж байна гэсэн үг. Хүүхдүүд хүүхэлдэйн кино үзэж байна.</p> <p><small>Гадагш гарахдаа болон орой унтахдаа ашиглаагүй цахилгаан хэрэгслээ унтраахдаа залгуураас нь заавал салгаж байгаарай</small></p>  <p>Бичлэг үзэж , ярилцана.</p>	
Бататган дүгнэх үе шат 17 мин	<p>Зургийг ажиглаад тохирох үйл явдалтай зураг зураарай.</p>  <p>Гэртээ байгаа цахилгаанаар ажилладаг эд зүйлсийн нэрийг бичээрэй.</p> 	<p>Үйл явдалтай зураг зурах</p>  <p>Эд зүйлсийн нэрийг бичих</p> <ol style="list-style-type: none"> 1. Зурагт 2. Индүү 3. Сэнс 4. Хөргөгч 5. Тоос сорогч 6. Үсний сэнс 	

Хичээл №5

Дүгнэлт сорил

Зорилго: Сурагчдын өмнө үзсэнийг бататган сайжруулах.

1. Би ямар үед гэрлээ унтраах ёстой вэ?

- А. Үргэлж
- Б. Зөвхөн санасан үедээ
- В. Унтраах шаардлагагүй



2. Ямар нэгэн зүйл идмээр санагдсан үедээ би:

Зургийг харгалзуулан холбоод зөвийг нь дугуйл.

- А. Хөргөгчөө онгойлгож хараад, тааралдснаа
- Б. Хөргөгчөө нээхээсээ өмнө юу идэхээ шийдсэн байна.
- В. Хөргөгчнийхөө хаалгыг нээж удаан харж байгаад хайснаа авна.



3. Би зурагтаа унтраахдаа:

Зургийг харгалзуулан холбоод зөвийг нь дугуйл.

А. Удирдлагаар



Б. Товчлуураар



В. Залгуураар



4. Зургийг харгалзуулан холбоод цахилгааныг хамгийн бага хэмнэх чийдэнг тэмдэглэ.

А. LED гэрлийн чийдэн



Б. Сүүн гэрлийн чийдэн



В. Улайсах гэрлийн чийдэн



5. Тохирох зурагтай нь холбо.

Сэнс



Нар



Гал



Хөргөгч

